

“ХАН-УУЛ ЯАРМАГ” ОНӨААТҮГ-ЫН ТАНИЛЦУУЛГА

2024 оны 12 сарын 18

Улаанбаатар хот

Манай байгууллага нь 2011 онд анх байгуулагдсан бөгөөд ХУД-ийн ИТХ-ийн 2013 оны 03-р сарын 15-ны өдрийн А/15 тоот тогтоолоор Хан-Уул дүүргийн харъяа “Хан-Уул яармаг” Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэр /ОНӨААТҮГ/ болж, өөрчлөгдөн байгуулагдсан. Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Одоогоор 60 орчим түрээслэгчидтэй Хан-Уул дүүргийн иргэдийг бизнес эрхлэх, ажиллах орчноор ханган ажиллаж байна. Үүнд: Хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, эмийн сан, барьцаалан зээлдүүлэх, цайны газар, үсчин, барилгын материалын худалдаа, дугуй засвар зэрэг худалдаа үйлчилгээг явуулж байна.

Мөн Хан-Уул дүүргийн засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/13 дугаар захирамжын дагуу Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, хөтөлбөр болон шинээр хэрэгжих барилга байгууламж, засвар тохижилт бүтээн байгуулалт, инженерийн шугам шүлжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж, чанар стандартын шаардлага хангуулж байнгын ашиглалтад оруулах зорилгоор Техник хяналтын алба ажиллаж байна.

Худалдааны төв нь Мягмар - Ням гаригт, өглөө 09:00 цагаас орой 20:00 цаг хүртэл ажилладаг. Даваа гаригт амарна.

Техник хяналтын алба нь Даваа - Баасан гариг хүртэл өглөө 09:00 цагаас орой 20:00 цаг хүртэл ажилладаг. Бямба, Ням гаригт амарна.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Нэгдүгээрт: Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ нь Хан-Уул дүүргийн алслагдсан Шувуун фабрик, Био комбинат, Туул тосгон, Өлзийт хороолол зэрэг суурин газрын иргэдэд худалдаа үйлчилгээг ойртуулах, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр шинээр бий болгох, иргэдийг эрүүл аюулгүй, хямд хүнсний бүтээгдэхүүнээр хангах

Хоёрдугаарт: Захилагчийн хяналтыг гүйцэтгэлийн үе шат бүрт холбогдох хууль тогтоомж, журам, стандартыг дагаж мөрдөн, гүйцэтгэгч байгууллагад зөв шаардлага тавьж, хариуцлагатай ажиллах

Албан ёсны цахим хуудас, сайт:

<https://www.facebook.com/profile.php?id=100064024453561>

Хаяг:

Яармаг худалдааны төвийн байршил:

<https://maps.app.goo.gl/oD22BzE7qH6K4Qu1A>

Техник хяналтын албаны байршил:

<https://maps.app.goo.gl/cA6WJy5utrkKHHWo8>